

## ДУА НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

### 2026 ОНЫ 4-Р САР ХАРИУЦСАН ТАСАГ НЭГЖИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2026.04.30

д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлсэн ажил	Хувь
1	<p><b>Давсны хэрэглээг бууруулах -7 хоног”</b> : “Давсны зохистой хэрэглээ” өдөрлөг</p>	<p>✓ “Давсны хэрэглээг бууруулах долоо хоног”-ийн хүрээнд 03/28-04/03 хугацаанд Поликлиник-1, Сэргээн засах эмчилгээний тасаг, Байгууламж менежментийн алба хамтран “Давсны хэрэглээг бууруулья” өдөрлөг зохион байгуулсан. Үйлчлүүлэгч 90 иргэнд өлөн үеийн цусан дахь глюкоз тодорхойлж, артерийн даралт хэмжин, “Давс бууруулах хоол шим тэжээл” гарын авлага- 90 ширхэг тараан өгсөн. Мөн Поликлиник-2 тасгаар үйчлүүлэгч 76 иргэнд мэдээлэл сургалт хийн, зөвлөмж тараан өгөв.</p> <p>✓ “Давсны хэрэглээг бууруулах долоо хоног”-ийн хүрээнд Дотрын тасгийн хэвтэн эмчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг хоол зүйч М.Булганзаяа, НЭМА Э.Ариунчимэг нар хамтран зохион байгуулсан. “Давс бууруулсан хоол, шим тэжээл” гарын авлага 16 ширхэг тараан өгсөн. Давсны хэрэглээг бууруулах зөвлөмж Реел -1 бэлтгэн цахим хуудсаар түгээсэн.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div>	100%
2	<p>Дархан хот байгуулагдсаны 65 жилийн ойг угтан хийж буй “ЦЭВЭР ХОТ” хаврын цэвэрлэгээ аяны хүрээнд НЭ-ийн гадна талбайн цэвэрлэгээг зохион байгуулах</p>	<p>“ЦЭВЭР ХОТ” хаврын цэвэрлэгээ аяны хүрээнд НЭ-ийн гадна талбайн цэвэрлэгээнд нийт-31 алба, тасаг нэгжийн – 283 ажилтан хамрагдсан.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div>	100%

<p>3</p>	<p>Эх барих, сувилагчдын өдрийг угтсан “ХАМТРАХ СОЕЛ-ХОРШИХ УХАМСАР-ЭВ НЭГДЭЛ” спортын 2 төрөлт тэмцээн</p>	<p>Эх баригч, сувилагчдын өдрийг угтсан “Хамтрах соёл – Хорших ухамсар – Эв нэгдэл” уриан дор зохион байгуулсан волейболын тэмцээн зохиог байгуулсан. Тус тэмцээнд байгууллагын эмч, сувилагч, ажилтнуудаас бүрдсэн эрэгтэй, эмэгтэй нийт 10 баг оролцож, хурд хүч, авхаалж самбаа, багаар ажиллах чадвараа сорин өрсөлдсөн.</p> <p>✓ Эмэгтэй багийн төрөлд: 1-р байр – П.Солонго ахлагчтай “Ахлахууд” баг 2-р байр – Т.Мягмарсүрэн ахлагчтай “We are nurses” баг 3-р байр – С.Сармандах ахлагчтай “Цэцэгс” баг</p> <p>✓ Эрэгтэй багийн төрөлд: 1-р байр – Э.Галсанпунцаг ахлагчтай 2-р баг 2-р байр – Т.Лхагва-Очир ахлагчтай 1-р баг 3-р байр – Г.Өлзийнэмэх ахлагчтай 4-р баг</p> <p>Энэхүү тэмцээн нь хамт олны эв нэгдлийг бэхжүүлэх, идэвх санаачилгыг нэмэгдүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг дэмжихэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон.</p>	<p>100%</p>
<p>4</p>	<p>БОЛОМЖ ҮРГЭЛЖ БАЙДАГ-46 сургалт үйл ажиллагаа:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хавдрын эмчилгээний үеийн хоол шим тэжээл” сургалт /ШУТИС Биотехнологи шим тэжээл судлалын профессор, Хүнс судлал-Биотехнологийн магистр, доктор М.Пүрэвжав/</li> <li>2. Хавдрын эмчилгээний үе, дараах үеийн нөхөн сэргээх эмчилгээ” сургалт Рехамед эмнэлэг, Сэргээн засах эмчилгээний тасгийн</li> </ol>	<p>“Боломж үргэлж байдаг” 46 дахь арга хэмжээ өдөрлөг сургалтыг “Наран Ижий Заяа” ТББ-ын тэргүүн даван туулагч Ш.Ариунаа, Толгой хүзүүний хавдрын зөвлөх зэргийн эмч , АУ-ны магистр клиникийн профессор Д. Мөнхцэцэг, Дархан Сэтгэл зүйчдийн холбооны тэргүүн М.Сарнай , “Түвшин энэрэл” Эм ханган нийлүүлэх байгууллагуудтай хамтран өдөрлөг, сургалт зохион байгуулсан. Үүнд:</p> <p>Дэлхийн эрүүл мэндийн өдөрт:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Боломж үргэлж байдаг-46 дахь арга хэмжээний хүрээнд Амбулаторийн үйлчлүүлэгчдэд нээлттэй өдөрлөг зохион байгуулж, иргэдэд мэдээлэл, гарын авлага түгээсэн. Нийт -60</li> <li>2. Хавдар онош батлагдсан үйлчлүүлэгч болон тэдний ар гэрийн нийт 46 иргэнд : “Толгой хүзүүний хавдар өвчнөөс сэргийлье” ,Бамбайн хорт хавдар” сэдэвт сургалтыг АУ магистр, клиникийн профессор зөвлөх зэргийн эмч Д.Мөнхцэцэг Хавдрын үеийн сэтгэл зүй сургалтыг Дархан сэтгэлзүйчдийн холбооны тэргүүн М.Сарнай Наран Ижий Заяа ТББ -ын тэргүүн Ариунаа “Хавдрыг даван туулах нь” сургалт мэдээлэл өгөв</li> <li>3. Өдөрлөгт Реел-1 бэлтгэн хийж түгээсэн, Постер-1</li> </ol> <p>Нэгдсэн эмнэлэг болон , Өрх сумын нийт 16 эмч эмнэлгийн мэргэжилтэнүүдэд сургалтууд зохион байгуулагдсан бөгөөд хавдрын эмч Д. Мөнхцэцэг бамбайн үзлэг хийн зөвлөгөө өгсөн.</p>	<p>100%</p>




	<p>эрхлэгч АУ -ны магистр Н.Цэрэнлхам//</p>		
<p>5</p>	<p>Галын аюулгүй байдал Онол болон дадлага сургалт зохион байгуулна</p>	<p>4 сарын 22-нд ОБГ-ын урьдчилан сэргийлэх, эрсдэлийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч Ч.Лхамсүрэнтэй хамтран “Галын аюулаас урьдчилан сэргийлэх” сэдвээр шинэ ажилтнуудад сургалт хийсэн. Үр дүн: Нийт 25 ажилтан оролцсон.</p> 	<p>100%</p>
<p>6</p>	<p>“СУВИЛАХУЙГ ТӨГӨЛДӨРЖҮҮЛЭХЭД СУВИЛАГЧ БИДНИЙ ОРОЛЦОО” уриан дор зохион байгуулагдах эрдэм шинжилгээний хурал</p>	<p>Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн сувилагч мэргэжилтнүүдийн дунд сувилахуйн тусламж үйлчилгээний тулгамдсан асуудал, ажлын байрны нөхцөл байдал, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагааг хэлэлцэх, нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээний үр дүнг мэргэжил нэгт сувилагч нарт таниулах, харилцан туршлага солилцох, судалгаа шинжилгээний ажлын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилготой “Эрдэм шинжилгээний бага хурал – 2026” зохион байгуулсан. Эрдэм шинжилгээний бага хуралд 30 гаруй сувилагч мэргэжилтнүүд оролцож, нийт 10 илтгэл хэлэлцүүлсэнээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Тэргүүн байр: Гэмтлийн тасгийн ахлах сувилагч Б.Хонгорзул, сувилагч Д.Сарангэрэл, М.Ариунтуул нарын “Гэмтлийн шалтгаант мэс засалд орохын өмнө насанд хүрэгчдийн сэтгэл түгшилт, гутралыг бууруулах аргыг туршсан үр дүн”сэдэвт илтгэл,</li> <li>✓ Дэд байр: Халдвартын тасгийн сувилагч Б.Нансалмаа, М.Ширзана, Б.Алтанням нарын “Бүслүүр үлд өвчний үеийн сувилахуйн оношинд тулгуурласан өвдөлтийн судалгаа” сэдэвт илтгэл,</li> <li>✓ Гутгаар байр: Дүрс оношлогооны тасгийн ахлах сувилагч С.Наранчимэг, сувилагч М.Жанчив нарын “Ходоод, улаан хоолойн уян дурангийн шинжилгээнд хамрагдалт болон дурангийн халдваргүйтгэлийн талаарх насанд хүрэгчдийн мэдлэгийг үнэлэх нь” сэдэвт илтгэл,</li> <li>✓ Тусгай байр: Мэс заслын тасгийн сувилагч Ц.Сарангэрэл, Э.Наранчимэг, Ц.Ганчимэг нарын “Асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийн хэрэгцээг судалсан дүн” сэдэвт илтгэлүүд тус тус шалгарсан.</li> </ul>	<p>100%</p>



7 “Ажлын байран дээр гарч болзошгүй осол түүнээс сэргийлэх, зааварчилгаа” сэдэвт богино хэмжээний бичлэг, видео контент НЭ-ийн пэйж хуудсан дээр байршуулж хандалт авах

ХАБЭА-н “Шилдэг хамт олон шалгаруулах аян”-ыг 1 сарын хугацаатай зохион байгуулж 2026.05.04-нд дүгнэж шалгаруулалт хийнэ. Шалгаруулалтын нэг үзүүлэлт болох видео контентийг НЭ-ийн пэйж дээр одоогийн байдлаар 3 тасаг байршуулсан.



100%

8 Нэгдсэн эмнэлэгт мэс заслын тасаг үүсч хөгжсөний түүхт 60 жилийн ойн ажлын хүрээнд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулах “Цэнхэр кодоор тусламж үзүүлэхэд бидний оролцоо” сэдэвт тэмцээн зохион байгуулах

5-р сард зохион байгуулагдахаар хойшлогдсон

-/-

**Нэмж хэрэгжүүлсэн ажил**

9 Сувилагч, тусгай мэргэжилтэнүүдэд халдварын

Халдварын сэргийлэлт хяналтын алба болон Төвлөрсөн ариутгал халдваргүйжүүлэлтийн тасгаас хамтран эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэхэд чиглэгдсэн ЭМС-ын тушаал, эрүүл

100%

	сэргийлэлт, хяналтын сургалт зохион байгуулах	<p>мэндийн тусламж үйлчилгээнд ашиглагдах багаж материал, хэрэгслийн халдваргүйтгэл, үүсэж байгаа эмнэлгийн тусгай хог хаягдлыг ангилан цуглуулах, түр хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааны талаар сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн халдварын сэргийлэлт, хяналтын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилго бүхий цуврал сургалтыг зохион байгуулсан.</p> 	
10	Асрагч нарын баримжаа олгох үргэлжилсэн сургалт зохион байгуулах	<p>Дархан нэгдсэн эмнэлгийн үйлчилгээний ажилтануудад “Эмнэлгийн байгууллагын онцлогт суурилсан баримжаа олгох ажлын байрны онол дадлага хосолсон хөтөлбөрт сургалт нь ёс зүй, харилцаа, хандлага, халдварын сэргийлэлт, цэвэрлэгээ үйлчилгээний стандарт болон тоног төхөөрөмжтэй ажиллах аюулгүй ажиллагаа, эрсдлээс сэргийлэх нь” сэдвүүдээр цуврал сургалтыг зохион байгуулсан.</p> 	100%
11	"ЧАДВАРЛАГ СУВИЛАГЧ" төвийн бүсийн ур чадварын тэмцээнд оролцох	<p>Олон улсын сувилагчдын өдрийг угтан ЭМЯ, Монголын Сувилагчдын Нийгэмлэг, Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг, Олон Улсын Улаанбаатар Их Сургууль болон Сэлэнгэ аймгийн ЭМГ-тай хамтран зохион байгуулсан. “Чадварлаг Сувилагч” төвийн бүсийн ур чадварын тэмцээнд Дархан –Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн Х.Бадамдагий ахлагчтай сувилагч нарын баг амжилттай оролцсон.</p> 	100%
12	"Мини олимп"-2026 Эрүүл мэндийн байгууллагуудын үйлдвэрчний эвлэлийн	<p>Эрүүл мэндийн байгууллагуудын үйлдвэрчний эвлэлийн хорооноос 2 жилд нэг удаа зохион байгуулдаг "Мини олимп"-2026, Спортын 5 төрлөөр, 400 гаруй тамирчид хурд, хүч, авхаалж самбаагаа сорин оролцож, багийн нийлбэр дүнгээр Дархан нэгдсэн эмнэлгийн хамт олон “Шилжин явах цом”-ын эзнээр тодорсон.</p>	100%

	хорооноос 2 жилд нэг удаа зохион байгуулдаг тэмцээн	 	
13	Уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулах	<p>Сувилахуйн албанаас санаачлан алба, тасаг нэгжүүдийн уялдаа холбоог сайжруулан хамтын оролцоонд тулгуурласан үр дүнтэй менежмент, бүтээмжийг бий болгох зорилго бүхий <b>“Нэгж бүр бүтээмжтэй –Ажилтан бүр хариуцлагатай”</b> сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг нийт сувилагч, тусгай мэргэжилтэнгүүд болон албадын дарга нарыг оролцуулан зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд захирал Б.Мөнхбат “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хөгжилд сувилагч, тусгай мэргэжилтний оролцоо, ирээдүйн төлөв” илтгэл танилцуулж, албадын дарга нар сувилахуйн албатай хамтран ажилласан үйл ажиллагаа, анхаарах асуудлын талаар илтгэлүүдийг хэлэлцүүлэн мөн сувилахуйн тусламж, үйлчилгээг гүйцэтгэхэд сувилагч нарт тулгамдаж байгаа асуудлаа удирдлагуудад хүргэх, асуудлыг шийдвэрлүүлэх, гарцыг тодорхойлсон үр дүнтэй уулзалт хэлэлцүүлэг болсон.</p>   	100%
14	Шинэ ажилтан чиглүүлэх сургалт	<p>Дархан Нэгдсэн эмнэлгийн хүний нөөц сургалт хөгжлийн албанаас шинэ ажилтанд зориулсан чиглүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулж хэвшсэн бөгөөд 2026 оны I улиралд шинээр ажилд орж буй хэн бүхэн мэдвэл зохих, мөрдөж хэвших зайлшгүй шаардлагатай байгууллагын соёл, эрүүл мэндийн байгууллагын халдвар хамгаалал, тусламж үйлчилгээний чанар,хөдөлмөр аюулгүй ажиллагаа болон эмнэлгийн мэргэжилтний ёс, төрийн албаны ёс зүй зэрэг нийт 11 чиглэлийн багц мэдээллийг албадуудын мэргэжилтэнгүүд хүргэсэн.</p>  	100%

<p>15</p>	<p>Эрүүл мэндийн лабораторийн мэргэжилтний 7 хоног тохиолдуулан өдөрлөг, сургалт зохион байгуулах</p>	<p>Жил бүрийн 4 дүгээр сарын сүүлийн долоо хоногт Дэлхий даяар "Эрүүл мэндийн лабораторийн мэргэжилтний 7 хоног"-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг. Эмнэл зүйн -Эмгэг судлалын лабораторийн тасгаас эмнэлгээр үйлчлүүлэгч иргэдэд "LAB WEEK- Эрүүл мэндийн лабораторийн мэргэжилтний 7 хоног" нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулав. Өдөрлөгийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Элэгний В, С вирусын илрүүлэг шинжилгээ-38 иргэнд</li> <li>✓ Эрдэсийн шинжилгээ 38 иргэнээс авч</li> <li>✓ Лабораторийн шинжилгээнд хэрхэн хамрагдах, лабораторийн үйл ажиллагаа болон тоног төхөөрөмжийн танилцуулга зэрэг 6 төрлийн гарын авлага-125 ширхэг тараан чиглүүлэх мэдээлэл өгч ажилласан.</li> </ul>	<p>100%</p>
-----------	---	---	-------------



Төлөвлөгөөнд нийт-8 ажил төлөвлөснөөс хойшлогдсон 1 ажил, нэмэлтээр 7 ажил хийсэн. Төлөвлөсөн ажлын хэрэгжилтийн биелэлт 93,3%. Сар хариуцсан нэгжүүдийн ажлын үр дүн 100%.

Тайлан гаргасан:

Сэргээн засах эмчилгээний тасаг, Поликлиник-1 тасаг, Байгууламж менежментийн алба